



БАЯНХОНГОР АЙМАГ
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 23 өдөр

Дугаар А/06

Хөхбүрд

Малын шилжих хөдөлгөөнийг хориглох
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 59.1.11, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.12.1, 7.12.3, аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн А/36 захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал, амьтны халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор сумын нутаг дэвсгэрт гадны аймаг, сумаас отор нүүдэл, үйлдвэр худалдаа, үржлийн болон бусад зорилгоор салаа туурайтан амьд мал, амьтан зөөвөрлөж тээвэрлэн байршуулахыг 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл хориглосугай.

2. Адуун сүргийг өөрийн сум, багийн нутаг дэвсгэрт нэвтрүүлэхдээ Мал эмнэлгийн гэрчилгээнд үндэслэн нийлүүлгийн өвчин, хачгийн халуун, адууны ям зэрэг өвчнүүдийн шинжилгээнд хамруулж, халдваргүйтгэл хийлгэн нэвтрүүлэхийг Мал эмнэлгийн тасгийн Тархвар зүйч (Ж.Ёндонпил), Мал эмнэлгийн аж ахуйн нэгжийн эмч нар, багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Малын ашиг шимийг нэмэгдүүлэх, цөм сүрэг бий болгох, өсвөр хээлтэгч өсгөх бойжуулах, худалдан борлуулах зэрэг ажлыг, өөрийн аймаг, орон нутгийн баталгаажсан үүлдэр, омгийн малыг сайжруулагчаар ашиглах нөөц боломжит тулгуурлан зохион байгуулахыг Хөдөө аж ахуйн тасаг, Багийн Засаг дарга нарт хариуцуулсугай.

4. Малчид, мал бүхий иргэдэд мал, амьтны шилжилт хөдөлгөөн, халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тухай сэрэмжлүүлж, ард иргэдэд уг захирамжийг танилцуулж мал, амьтны шилжилт хөдөлгөөнд хяналт тавьж,

642201179

захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Мал эмнэлгийн тасаг, Хөдөө аж ахуйн тасаг, Багийн Засаг дарга нар, Цагдаагийн хэсэгт даалгасугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (М.Жавзансүрэн)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Ж.ХАТАНБААТАР

